



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, <http://www.frc.mn>

2022.12.06 № ЦМ-7/178 .

танай 2022.11.14 -ны № 42/789 -т

Г “ТАВАН БОГД ФИНАНС ББСБ” ХХК-Д Г

“Таван богд финанс ББСБ” ХХК-ийн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг дэх салбарын захирлыг өөрчлөх хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авч, хянаж үзэхэд салбарын захирлаар томилохоор ирүүлсэн Алтангэрэл овогтой Чимэгээ нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.6 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаж байгаа тул салбарын захирал Х.Пүрэвнямыг өөрчилж, Хорооны холбогдох бүртгэлд бүртгэсэн болно.

Салбарын захирал өөрчлөгдсөнтэй холбогдуулан Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэгээ хийлгэж, холбогдох баримт бичгийг ажлын 10 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг мэдэгдье.

